

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах
талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Улаанбаатар хотын агаарын бохирдол нийслэлийн хүн амын эрүүл мэндэд аюул учруулахуйц гамшгийн хэмжээнд хүрснийг тэмдэглэж, энэ талаар хойшлуулшгүй арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Улсын Их Хуралд:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн төсөл, хэрэгжүүлэхтэй холбогдсон тогтоолын төслийг 2010 оны намрын чуулганаар баталж мөрдүүлэх;

2. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих Үндэсний хороог Улсын Их Хурлын дэд даргаар ахлуулан байгуулж ажиллах.

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчид:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн төсөл, хэрэгжүүлэхтэй холбогдсон Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Гурав. Засгийн газарт:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

2. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн тодотголыг боловсруулж Улсын Их Хурлын 2011 оны хаврын чуулганаар батлуулах.